



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/224

Булган сум

“Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл”-ийг  
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28-р зүйлийн 28.1, 28.2, 28.3 дахь заалт, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж, нийгмийн түншлэгч талуудын оролцоог хангах, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг удирдан зохицуулах чиг үүрэг бүхий “Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Салбар зөвлөлийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

А.Оюунжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Д.Мэндсайхан (Аймгийн Ажил олгогч эздийн холбооны  
тэргүүн)

Д.Баярмагнай (Аймгийн Ажил олгогч эздийн холбооны  
тэргүүлэгч)

Ч.Отгонжаргал (Аймгийн Ажил олгогч эздийн холбооны  
тэргүүлэгч)

Д.Баярсайхан (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн  
холбооны дарга)

Т.Дорж (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны  
тэргүүлэгч)

Ч.Оюун (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны  
тэргүүлэгч)

Нарийн бичгийн дарга: Г.Нямдорж (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын  
Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга)

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг орон нутагт хэрэгжүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжигдэх төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тайлан мэдээг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох байгууллага, албан

тушаалтныг эргэн мэдээллээр хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөлийн дарга (О.Ундрах)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/715 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д. ПҮРЭВ-ОЧИР